

3.3 ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Үндэсний геологийн алба /агентлаг/
Тайлант хугацаа: 2021.12.31
Аудитын код: Түүвэр

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болгосон		Асуудлыг шийдвэрлэсэн байдал			Гаргасан шийдэл	Хэрэгжүүлсэн үр дүн
				Холбогдох хууль тогтоомжийн нэр, заалт	Холбогдох стандартын нэр, заалт	Аудиторын санал	Аудитыг хянан удирдах ажилтнуудын санал			
							Менежер	Тэргүүлэх аудитор		
A	1	2	3	5	6	7	8	9	10	11
1	Мөнгөн хөрөнгө	Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ бүртгэлд тусгасан	4,500.0	НББ-ийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно",		Зөвлөмж	Зөвлөмж	Зөвлөмж	НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." мөн иж бүрэн байх зарчмийг баримтлаж ажиллаж байна.	100%
2	Төсөв гүйцэтгэл	Батлагдсан эдийн засгийн ангиллыг мөрдөөгүй, зохих журмын дагуу төсөвт зохицуулалт хийлгээгүй нийт 15,128.5 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй.	15,128.5	Төсвийн тухай хуулийн 22.1. "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана. 22.2.3.эдийн засгийн ангиллаар", Сангийн сайдын 2014 оны 55, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-тай нийцээгүй		Зөвлөмж	Зөвлөмж	Зөвлөмж	Төсвийн тухай хуулийн 22.1. "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана. 22.2.3.эдийн засгийн ангиллаар", Сангийн сайдын 2014 оны 55, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-тай нийцүүлэн 2022 оны эхний 3 дугаар улирлын байдлаар ангилал зөрүүлж ажиллаагүй.	100%
3	Зардал	Газрын даргад дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүйгээр үр дүнгийн болон ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй үеийн мөнгөн урамшуулал бодож олгосон.	3,155.1	Засгийн Газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8.3.3. "агентлагийн төсвийн ерөнхий менежерийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулах, биелэлтийг хангах", Төрийн албаны тухай хуулийн 52.1. "Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж дүгнэнэ". НББ-ийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно",		Төлбөрийн акт	Төлбөрийн акт	Акт	Тухайн актыг О.Чулуун өөрөө төлсөн бөгөөд 3,155.1 мянган төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр төвлөрүүлсэн болно.	100%
4	Зардал	Тайлант онд нийт 43,021.7 мянган төгрөгийн урамшуулал бодож олгосон.	43,021.7	МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.		Зөвлөмж	Албан шаардлага	АШ	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.41 дүгээр зүйлийн 41.2.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйдийн 101.1 заасныг дагаж мөрдөнө ажиллаж байна.	100%

5	Биет бус хөрөнгө	Биет бус хөрөнгө буюу нийт 62,131.9 сая төгрөгийн геологийн судалгааны ажлын тайлангуудыг бөөн дүнгээр, 2 ширхэгээр нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.		Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх; 5.1.5.хэмжигдэхүйц байх".	УСНББОУС-12 Бараа материал	Зөвлөмж	Зөвлөмж	Зөвлөмж	Биет бус хөрөнгийг тайлан тус бүрээр салган код үүсгэн орлогод бүртгэсэн.	100%
6	Орлого	Архивын лавлагааны болон мэдээлэл технологийн үйлчилгээний орлого бүрдүүлэлттэй холбоотой анхан шатны баримт бүрдүүлж, архивын нэгж үүсгээгүй, холбогдох мэргэжилтнүүдээр тайлан гаргуулж, тооцоо хийж хэвшээгүй байна. Мөн ТЕЗ-ийн төлөвлөгөөнд тус орлогыг АМГТГ бүрдүүлэхээр баталж байна.		Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй.		Зөвлөмж	Зөвлөмж	Зөвлөмж	Үндэсний геологийн алба нь Засгийн газрын 2020 ны 06 дугаар сарын 23-ны өдрийн "Агентлаг байгуулах тухай" 230 дугаар тогтоолоор байгуулагдсан. 2020 оны 09 дүгээр сард албан ёсоор Ашигт малтмал газрын тосны газраас тусгаарлагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Байгуулагдсан цагаас хойш буюу өнөөг хүртэл Геологийн мэдээллийн төв болон Геологийн төв архиваас Улсын төсөвт төвлөрүүлж буй үйлчилгээний орлогыг Ашигт малтмал, газрын тосны газрын Улсын төсөвт төвлөрүүлж байна. Үндэсний аудитын зөвлөмжийн дагуу 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдөр УУХУЯаманд орлогын төлөвлөгөө салгуулах 1/395 тоот албан бичгийг явуулсан.	90%
7	Авлага, өглөг	Санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж хэвшээгүй.		Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасантай нийцээгүй.		Зөвлөмж	Зөвлөмж	Зөвлөмж	2022 оны эхний 3 дэгээр улирлын байдлаар харилцагч аж ахуйн нэгжүүдтэй улирал бүрийн эцэт тооцоо нийлж баталгаажуулан ажиллаж байна.	100%
8	Нягтлан бодох бүртгэл	Урьдчилж төлсөн төлбөр буюу даатгал, програм хангамжийн лицензийн төлбөр зэрэг ажил үйлчилгээний төлбөрийн хэрэгжих хугацаа дуусаагүй байхад тайлант үеийн зардлаар бүртгэсэн.	45,530.8	Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 хавсралтаар баталсан заавар аргачлалын 4.26 "Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг урьдчилж төлсөн урьдчилгаа болон урьдчилан төлсөн зарлуудыг урьдчилж төлсөн төлбөр /зардал/ гэнэ. Энэ нь төлбөр хийгдсэн боловч тайлант хугацаанд гараагүй байгаа зардал учраас хөрөнгө гэж бүртгэнэ. Урьдчилж төлсөн төлбөрүүд нь: • бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа тооцоо • урьдчилж төлсөн зардал /түрээс, даатгал, татварын төлбөр/" гэж заасантай нийцээгүй байна.		Залруулга хийх	Залруулга хийх	Залруулга	Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 хавсралтаар баталсан заавар аргачлалын 4.26 "Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг урьдчилж төлсөн урьдчилгаа болон урьдчилан төлсөн зарлуудыг урьдчилж төлсөн төлбөр /зардал/ гэнэ. НББ-н стандартын дагуу залруулга хийсэн.	100%
9	Хууль нийцэл	Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт батлаагүй, ямар нэгэн үнэлгээгүйгээр сар бүр тогтмол 10-25 хувиар тооцож олгосон.		Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын 4. "Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно" гэж заасантай нийцээгүй.		Хууль нийцлийн асуудал	Албан шаардлага	АШ	Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын 4. "Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно" гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	85%

10	Зардлын данстай холбоотой	Геологи судалгааны ажил гүйцэтгэхээр 2012-2014 онуудад гэрээ байгуулсан 3 байгууллагын 1,528,577.9 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр дүгнүүлээгүй. Үүнээс 1 байгууллагын 584,785.0 мянган төгрөгийн судалгааны ажил шүүхэд шилжсэн, төсөл гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд тавих хяналт болон гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байгаа нь Уул уурхайн сайдын 2015 оны 108 тоот "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 3.19. Төслийн геологийн даалгаврын хугацааг хэтрүүлж хэрэгжүүлсэн тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төсөлд зарцуулсан нийт зардлын дүнгийн 0.03 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг гүйцэтгэгч нарт ногдуулах", 4.1 "Төсөл гүйцэтгэгчийн ажлын үр дүн болон ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор хээрийн судалгааны болон суурин боловсруулалтын ажлын гүйцэтгэлд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагаас шуурхай хяналтыг гүйцэтгэн төсөл зохих арга аргачлалын дагуу хэрэгжиж байгаа эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг шалгаж, аргачлалын зөвлөлгөө өгнө" заалтыг хэрэгжүүлээгүй байна.	943.8	Холбогдох эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцоох албан шаардлага хүргүүлэх		Хууль нийцлийн асуудал	Албан шаардлага	АШ	2013-2016 онуудад хэрэгжих байсан боловч тодорхой шалтгааны улмаас зогсоод байсан 2 төслийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ЭБМЗ-ийн хурлаар оруулж хэлэлцүүлэх үүднээс төслийн удирдагч, компанийн удирдлагуудтай уулзалтуудыг хийж, төслийн ажилтай танилцаж тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх мэргэжил арга зүйн тусламж үзүүлж ирснээр 2 төслийн тайлан боловсруулалтын ажил дуусах шатандаа явж байна. Үүнд: 1. "Цагдуултайн Ундарга" ХХК-ийн хэрэгжүүлж буй "УГЗ-200 Дорнод Монгол-VII" төслийг иж бүрдэл зураг зохиох төсөл. - Тоон мэдээлэл, сан бүрдүүлэлтэд УГА-ны ГМТ-ийн ахлах ажилтан А.Амаржарга мэргэжил, аргазүйн зөвлөмжөөр ханган ажилласан. Мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж дуусах шатандаа явж байна. - ГСХ-ээс төслийн ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын геологийн Холбоо, ТБХ гаас зөвлөх, мэргэшсэн геологич нарыг урьж, Геологи, дөрөвдөгч, экологи-геологийн зураг, тайлбар бичиг боловсруулалтын ажилд мэргэшсэн геологи Д.Төрмгнай, Ашигт малтмалын бүлгийн боловсруулалт тайлан бичвэрт Монгол улсын зөвлөх инженер С.Мөнхбадрах нар мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байна. - Одоо хяналт завсар хийгдэж дууссаны дараа шинжээч нараар дүгнэлт тайлбар гаргуулахаар бэлтгэж байгаа. 2. "Жи Си Эс" ХХК-ийн хэрэгжүүлж буй 1:50000-ны масштабын геологийн зураглал ерөнхий эрлийн ажлын Шивээт-50 төсөл. - ГСХ-ээс Шивээт-50 төслийн удирдагч С.Жамъянсүрэнтэй 2022 оны 01 дүгээр сарын 2 ний уулзалт хийж, төслийн явц, үр дүн, тулгамдаж буй асуудлуудын талаар тайлбар мэдээлэл авч мэргэжил аргазүйн зөвлөмж өгсөн. - Тайлангийн зургийн явц 80 хувьтай боловсон хүчний дутагдалтай байдлаас тайла боловсруулалтын ажил удаашралтай явж байсан. Одоогийн байдлаар Монгол улсын зөвлөх, мэргэшсэн геологич Ч.Төмөрчөдөр, Ганбаяр нар интрузивын бүлгийн зураг, бичвэрийн ажлыг гүйцэтгэж дуусаад байна. - Ашигт малтмалын зураг, бичвэрийн ажлыг төслийн удирдагч С.Жамъянсүрэн гүйцэтгэж байгаа бөгөөд үр дүнгийн тайлангийн зураг, тайлбар бичгийг боловсруулах, хяналт завсарын ажил хийгдэж байна.	85%
11	Зардлын данстай холбоотой	Геологи судалгааны ажил гүйцэтгэхээр 2017-2018 онуудад гэрээ байгуулж 2019-2020 онуудад дуусах нийт 45,153,552.5 мянган төгрөгийн судалгааны ажлын санхүүжилт олгогдсоноос 42,369,333.6 мянган төгрөгийн ажил гүйцэтгэж гүйцэтгэлийн 84.0 хувь буюу 35,397,137.3 мянган төгрөгийн гэрээ дүгнэгдэж, 16.0 хувь буюу 6,972,196.3 мянган төгрөгийн гэрээ цар тахлын нөхцөл байдал, ЭБМЗ-ийн хурлын тов хүлээж байгаа буюу буцаагдсан зэрэг шалтгаанаар гэрээ дүгнэгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; заалтыг хэрэгжүүлээгүй байна.	6,972.2	Албан шаардлага		Хууль нийцлийн асуудал	Албан шаардлага	АШ	Норовлин-50, Сүүжийн говь-50, Чулуун хороот-50, Шүтээн улаан уул-50, Бүрхтэй уул-50, Галбын говь-50 төслүүд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт болон УУХҮСайдын тушаал гарсан одоо ГБТА анхдагчийг хүлээн авах, гэрээ дүгнэх ажил явагдаж байна - УБ Геоэкологи-2017, Цайлангийн нуруу-50 төслүүд 2022 оны оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж засвар оруулахаар буцаагдсан одоо засварын ажил хийгдэж ЭБМЗ-ийн хурлаар орох товыг хүлээж байна - Цайлангийн нуруу-50 төсөл Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өдрийн дүгнэлт гарсан одоо УУХҮСайдын тушаалыг хүлээж байна - Их өлзийт-50 төслийн геологийн даалгаврын хугацааг цар тахлаас үүдэлтэй 9 сараар сунгуулсан одоо ЭБМЗ-өөс шинжээч Г.Ганбаярыг үр дүнгийн тайланд шүүмжлэгчээр томилон ажиллуулж байна. Тайланг 12 дугаар сард багтаан хүлээн авахаар төлөвлөн ажиллаж байна. - Асгат уул-50 төсөл Үр дүнгийн тайлангийн геологийн даалгаврын хугацааг цар тахлаас үүдэлтэй 4 сараар сунгуулсан Монголын стратиграфийн комиссын хуралдаанаар орсон одоо ЭБМЗ-өөс шинжээч М.Тодбилэг, С.Төмөр нарыг үр дүнгийн тайланд шүүмжлэгчээр томилон ажиллуулж байна. Тайланг 12 дугаар сард багтаан хүлээн авахаар төлөвлөн ажиллаж байна. - Дэвийн хонгор уул-50 төсөл Үр дүнгийн тайлангийн геологийн даалгаврын хугацааг цар тахлаас үүдэлтэй 3 сараар сунгуулсан Монголын стратиграфийн комиссын хуралдаанаар орсон одоо ЭБМЗ-өөс шинжээч Д.Оролмаа, Д.Цолмон нарыг үр дүнгийн тайланд шүүмжлэгчээр томилон ажиллуулж байна. Тайланг 12 дугаар сард багтаан хүлээн авахаар төлөвлөн ажиллаж байна. - Стратегийн ашигт малтмалын хэтийн төлөв /ГАСАМ/ төсөл Тайланг 6 сард бичиж дуусгасан ба 2020/07/26-ны өдөр шинжээч Д.Доржготов, Ч.Гэрэлхүү нарыг томилон ажиллуулж байна. Тайланг 12 дугаар сард багтаан хүлээн авахаар төлөвлөн ажиллаж байна.	80%
			119,252.1							

Бэлтгэсэн:
Ахлах аудитор
Хянасан:

Б.Эрдэнэзул

Огноо:

Хэрэгжилтийг тайлагнасан:
Үндэсний геологийн

О.Чулуун

Аудитын менежер

Д.Энхдалай

Огноо:

Нягтлан бодогч

Э.Мягмарсайхан

Аудитын хоёрдугаар газрын захирал,
Тэргүүлэх аудитор

Ц.Наранчимэг

Огноо:

ЭБСТЭХЗ-ийн мэргэжилтэн
ГСХ-ийн мэргэжилтэн

И.Баттуяа
Х.Ганхуяг